

ХУУЛЬ, ТОГТООМЖ , ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 оны 02 дугаар сарын 29

Улаанбаатар хот

Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллагын үнэлгээ	Хариуцан хэрэгжүүлэх нэгж
1	2	3	4	5	6	7	8
Засгын газрын тогтоол							
1.	1.	“Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” батлах тухай 2021-03-10 Дугаар 2021_58	3. Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай.	2021, 2022 онуудад төсөлд хамрагдсан залуучуудтай холбогдож ажил эрхлэлтийн талаар судалгаа авч ажлын байраар хангах талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. 2023 онд нийт 80 залуу байнгын ажлын байранд ажиллаж байна. -5 оролцогчид ажил олгогчоос ирүүлсэн сул чөлөөтэй ажлын байр санал болгосон. -Мэргэжилгүй 3 залууг мэргэжил олгох сургалтад хамруулахаар бүртгүүлсэн. -Хөдөлмөрт бэлтгэх сургалт, Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 3 оролцогчийг хамруулсан.			НХХ
2.	2.	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр	2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс дүүргийн 43 хороодын нийт албан хаагчдад Монгол бичгийн ахисан түвшний практик сургалтыг зохион байгуулж байна.			ТЗУХ

			үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.				
3.	3.	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139	1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан "Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх" богино хугацааны сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулж 101 ажилтан албан хаагч хамрагдан сертификат авсан.			ТЗУХ

			“Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.				
	4.		3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг “Удирдлагын академи”-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.	Удирдлагын академийн төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газраас 10 албан хаагчийг хамруулахаар төлөвлөж 2024 оны төсөвт тусган ажиллаж байна.			
4.	5.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_203	1. 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу Дэд бүтэц хот төлөвлөлтийн асуудал хариуцсан Засаг даргын орлогчийг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Б/62 дугаар, Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан Засаг даргын орлогчийг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Б/63, Цахим хөгжил, төрийн үйлчилгээ хариуцсан Засаг даргын орлогчийг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Б/60 дугаар захирамжаар тус тус ажлаас чөлөөлсөн болно			ТЗУХ

			холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;				
5.	6.	Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хөгжлийн төсөл арга хэмжээг эрчимжүүлэх тухай 2022-06-08 Дугаар 2022_226	1. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зургийг боловсруулан, бэлтгэл ажлыг хангаж, хэрэгжилтийг эрчимжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт үүрэг болгосугай.	Хот, хөдөөгийн сэргэлт-н хүрээнд ачаалал ихтэй гэр хорооллын байршлууд болон сургууль, цэцэрлэгийн ойр орчимд 2021-2023 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 55 байршилд нийт 34,7 км авто замын ажлыг хийж ашиглалтад оруулсан. 2024 онд 12 байршилд 11.7км авто зам, 1 байршилд гүүрэн байгууламж хийхээр төлөвлөн, техникийн болон ажлын зургийг боловсруулан, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.			ТГУХ
	7.		2. Энэ тогтоолын 1-д заасан хөгжлийн төсөл, арга хэмжээг бодлогын баримт бичигт заасан хугацаанд багтаан хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцож жил бүрийн	2023 оны 06 дугаар сард хэрэгжинэ.			

			нийслэлийн төсвийн төсөлд үе шаттай тусгаж байхыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.				
6.	8.	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 72 дугаар тогтоолын дагуу Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх ажлыг хувийн хэвшилд шилжүүлэх ажлын хүрээнд хог тээврийн үйлчилгээ үзүүлэх байгууллага сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж 1 дүгээр бүсэд “Элит стэри” ХХК, 2 дугаар бүсэд “Цагаанаа амка” ХХК, 3 дугаар бүсэд “Лонг балюстрад” ХХК, 4 дүгээр бүсэд “Үйлст мандал” ХХК-ууд шалгарч 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн хариуцсан бүсэд үйл ажиллагааг эхлүүлээд байна.			ТЗУХ
7.	9.	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448	2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр	1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулан ажиллаж байна. 2. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны			СТСХ

		батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS- www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах.	үр дүнд бий болсон 1,009.9 мянган төгрөгийн хэмнэлтийг зарцуулаагүй болно. 3. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн “Дүүргийн 2023 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 78 дугаар тогтоолоор батлагдсан 109 төсөл арга хэмжээний 79,673.7 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлийн дагуу 83 төсөл арга хэмжээний 42,499.7 мянган төгрөгийг санхүүжилт олгон ажилласан. 4. Барилгын материалын үнийн өсөлтөөс шалтгаалж хөрөнгө оруулалтын 4 төсөл арга хэмжээний 1,143.7 мянган төгрөгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан. 5. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS- www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан.			
--	--	--	---	--	--	--

8.	10.	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_55	1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжилтийн эрх дүүрэгт шилжин ирдэггүй			СТСХ
9.	11.	Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_63	3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.				ХХҮХ
10.	12.	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2023-04-05 Дугаар 2023_119	2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан 690 иргэнд мөнгөн төлбөр тогтоон 2023 онд 704,178,700 төгрөгийг Нийслэлийн төрийн санд төвлөрүүлсэн.			ЦШ
11.	13.	Төрийн албаны зарим албан тушаалын	2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн	"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын дагуу дүүргийн			ТЗУХ

		цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_241	тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн, 2024 оны төсөвт тусгасан.			
12.	14.	Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278	2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.	2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, хөгжлийн бодлого, зорилго болон зорилтыг хангах зорилгоор төсөл арга хэмжээг төлөвлөж 2023 оны 12 дугаар сарын 13-ны иргэдийн Төлөөлөгчдийн 15 дугаар хуралдааны 80 дугаар тогтоолоор баталсан. 2024 оны төсөвт жил дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 76 төсөл, арга хэмжээ, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 19 төсөл, арга хэмжээг шинээр хийж хэрэгжүүлэхээр иргэд, олон нийтийн саналыг үндэслэн баталсан			ТГУХ
13.	15.	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2023-07-19 Дугаар 2023_279	2.5.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;				ХХҮХ
14.	16.	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд	2. Цэргийн дүйцүүлэх алба хаах арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг аймаг,	Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн			ЦШ

		хязгаарыг тогтоох тухай 2023-08-23 Дугаар 2023_304	нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Хурлын Тэргүүлэгчдийн 2023 оны “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тоог батлах тухай” 44 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг элсүүлэх тухай” А/469 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын А/354 дүгээр тушаалаар 10 иргэнийг цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд элсүүлэн авсан.			
15.	17.	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321	2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, их дээд сургууль, ЕБС, СӨБ, Төрийн байгууллагууд, 41 ӨЭМТ-үүдээр дамжуулан “Сэтгэцийн эрүүл мэнд”, “Сэтгэл зүйн боловсрол”, “Сэтгэл зүйдээ анхаарал хадуулах нь эмгэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтуудыг зохион байгуулан, мэдээлэл зөвлөгөө өгч мөн оролцоонд тулгуурлан асуулт хариулт, чөлөөт ярилцлага, хамт олны харилцааг сайжруулах, өөрийн мэдрэмжийг гадагшлуулж суралцах сэтгэл зүйн дасгал ажил явуулан, сэтгэл зүйн боловсролын тараах материал өгөн сургалт, сурталчилгааг зохион байгуулан ажиллаж байна. Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн төв болон 41 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн цахим хаяг болон гарын авлагаар үзлэг хийж буй газруудын байршил мэдээллийг байршуулан иргэдэд нээлттэй мэдээлэл хүргэж, уриалан ажиллаж байна.			НХХ
16.	18.	“Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай	2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд	Дүүргийн хэмжээнд төрийн өмчийн 59 цэцэрлэг, төрийн бус өмчийн 129 цэцэрлэгт өдөр бүр шүд угаахыг хөтөлбөрөөр			НХХ

		2023-08-30 Дугаар 2023_322	өдөр бүр “Шүд угаах цаг”-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	хэрэгжүүлэн ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулиудад “Шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн төвөөс төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.			
17.	19.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-13 Дугаар 2023_456	1.1.. 1 .Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 1.1. .Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх;	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжилтийн эрх дүүрэгт шилжин ирдэггүй			СТСХ
	20.		1.2.. 1.2. улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэхээр гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжилтийн эрх дүүрэгт шилжин ирдэггүй			

			олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах;				
	21.		1.3.. 1.3. төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжилтийн эрх дүүрэгт шилжин ирдэггүй			
18.	22.	Аргачлал шинэчлэн батлах тухай (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал) 2023-12-20 Дугаар 2023_457	2. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2024 оны төсвийн жилээс эхлэн энэ тогтоолын 1-д заасан аргачлалын дагуу тооцон хуваарилж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	1.Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2024 оны төсвийн жилээс эхлэн энэ тогтоолын 1-д заасан аргачлалын дагуу тооцон дүүргийн 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хувиарлалтыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 5,205.1 мянган төгрөгөөр батлуулсан.			ТГУХ, СТСХ
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							
19.	23.	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11	XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ	Дүүргийн хэмжээнд Газар зохион байгуулалтын I, II алба, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс нийт 7 байгууллагын 283 үйлчилгээний 194 буюу 68.6% нь цахим хэлбэрт шилжсэн байна.			ТЗУХ

			үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	Мөн Нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг “Нэг цонхны үйлчилгээ”-нд шуурхай шилжүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд Төр захиргааны 2-р байр, “Дарь-Эх” нэг цэгийн үйлчилгээний байр, “Жанжин клуб”-ын байруудад Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээгээр 30 гаруй төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна			
20.	24.	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	ХХ.5. . Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, стандартын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав;	Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс гал түймэрт өртсөн Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны Эдү хотхоны орон сууцны барилга байгууламжид цаашид ашиглах боломжтой эсэх талаар судалгаа шинжилгээний ажлыг хийж байна. Холбогдох байгууллагуудаас дүгнэлт гараагүй байна. 2024 оны 03 дугаар сарын 29-ны дотор дүгнэлт гаргахаар ажиллаж байгаа талаар Хотын стандарт хяналтын газрын Барилгын стандарт аюулгүй байдал, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн /улсын байцаагч/ З.Ганбатаас мэдээллийг авч ажиллалаа.			ТНААХ

21.	25.		XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх иргэдэд тоон гарын үсгийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл хүргэх үйл ажилгааны хүрээнд төрийн болон бусад байгууллагуудад тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд цэгүүдийн КИОСК машин болон үйлчилгээний цонх, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа болон "Gsign" аппликейшны хэрэглээг нэмэгдүүлэн мөн хаан банкны киоск машинаар тоон гарын үсгийг олгож байна. Баянзүрх дүүргийн хэмжээнд тоон гарын үсгийг хэрхэн хаана ашиглах зөвлөгөө өгөн ажиллаж нийт 625 иргэнд тоон гарын үсэг олгосон. Мөн цахим QR кодыг иргэдэд хэвлэмэл цаасаар бэлтгэж QR кодыг уншуулж улсын бүртгэлийн иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн үйлчилгээтэй дэлгэрэнгүй танилцах боломжийг таниулж, улсын бүртгэлийн үйлчилгээг Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 5 цэгээс авах боломжтой талаар мэдээлэл өгсөн.			Улсын бүртгэлийн хэлтэс
22.	26.	2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33	XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр	4.2 МУ-ын ЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 237-р тогтоолоор тэтгэвэр 325,000 төгрөг, асаргааны тэтгэмж 275,000 төгрөг болж тус тус нэмэгдэн 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна. 2024 оны 02-р сарын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт 2638 иргэн хамрагдаж 1,7 тэрбум төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 1449 хүүхдэд 943,9 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа 1509 иргэнд 804,0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч			НХХ

		эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан саналаа шаардагдах зардлын тооцооллын хамт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.2. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийн хэмжээг 288,000 төгрөгөөр үргэлжлүүлэн олгох болон цаашид уг хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; 4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд шаардлагатай хүний нөөцийн судалгааг хийж, дутагдалтай	байгаа 1394 иргэнд 728,9 сая төгрөг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа 2809 иргэнд 1,4 тэрбум төгрөгийг тус тус олгосон. 4.3 Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвөөс лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй болгох нэмэгдүүлэх ажлын хүрээнд Сул орон тоонд сонгон шалгаруулахын тулд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. 2023 онд Сул орон тоонд сонгон шалгаруулахын тулд Эрүүл мэндийн салбарын холбогдох цахим хуудас болон Эрүүл мэндийн төвийн цахим хуудсаар сул орон тоог нээлттэй зарлаж, 3-5 хоногоор туршин ажиллуулж нийт 105 ажилтныг шинээр ажилд авсан. Эрүүл мэндийн төвд 4 салбар амбулаториор 150 эмч тусламж үйлчилгээ үзүүлж ажиллаж байна. Хүний нөөцийн хангалт 99%тай. 4.4 БЗДЭМТ нь 2023 онд хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Үүнд: - Профессор цолны 10 хувийн нэмэгдлийг 13 ажилтанд, Мэргэшлийн тэргүүлэх зэргийн нэмэгдлийг 34 эмнэлгийн мэргэжилтэнд, Мэргэшлийн ахлах зэргийн нэмэгдлийг 55 эмнэлгийн мэргэжилтэнд, Эх барих эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр үе, сүрьеэгийн кабинетын хэвийн бус нөхцлийн нөхцлийн болон сүрьеэгийн кабинетын нэмэгдлийг 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сар бүр 10 болон 30 хувиар тогтмол олгосон.			
--	--	--	--	--	--	--

		байгаа мэргэжилтнийг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар бэлтгэх, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.4. хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлийн богино хугацааны сургалтад хамруулж, энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэх, цаашид мэргэжил эзэмшихэд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.6. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийг үнэлэх Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	- Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолын дагуу эмч, ажиллагсдын 2023 оны 1,2,3-р улирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж үнэлгээгээр 352 ажилтанд 693,947,345 төгрөгийн урамшуулал олгосон. - Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны Б/37 дугаар тушаалаар ТҮЭМ, ТҮ зэрэглэлийн эмч, ажилтнуудын үндсэн цалинг 100,000 төгрөгөөр 2023.01.02-ноос нэмэгдүүлсэн. - Гэмтэл, мэс заслын эмч сувилагч, чанарын багийн гишүүд, Ахлах сувилагч, Халдварын сэргийлэлт хяналтын багийн гишүүд, эд хөрөнгө хариуцдаг ажилтнуудад сар бүр 5-10 хувийн нэмэгдлийг 2023.02.01-нээс олгож эхэлсэн. -Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор 2023.01.01-нээс төрийн алба хаасан жил тутамд нэмэгдэл олгохоор заасантай холбоотойгоор бүх ажилтны ажилласан жил тулгалт, өмнө ажиллаж байсан төрийн байгууллагын мэдээллийн тулгалтыг Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн програмд хийснээр 2023.01.01-нээс нийт 324 ажилтанд 1-25 хувиар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон. - Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор ТҮЭМ, ТҮ зэрэглэлийн цалингийн доод хэмжээг 2023.07.01-нээс шинэчлэн батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны А/71 дүгээр тушаалаар нийт ажилчдын цалинг 2023.06.01-нээс үндсэн цалинг 300,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн. Энэхүү тушаалаар үндсэн цалингийн доод хэмжээ 1,289,855 төгрөг, дээд хэмжээ 1,664,899 төгрөг болсон байна.			
--	--	---	---	--	--	--

			А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.7. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулах асуудлыг судалж, шаардагдах санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.8. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн эрүүл мэнд, сэргээн заслын цогц тусламж, үйлчилгээг өргөжүүлж, мэргэжил, арга зүй, хүний нөөц, эм хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.9. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн	4.9. “Амжилтын гэгээн од” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг байгуулан 2021 оноос хойш хамтран ажиллаж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар төрөөс баримтлах бодлого, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах, хөгжих, оролцох боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчныг бүрдүүлэх, олон нийтэд эерэг хандлагыг төлөвшүүлэх, чиглэлээр хамран ажиллаж байна. Тусгай хэрэгцээт хүүхдэд цогц үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр “Ихэр төөнүүрхэн” “Эрхэм нандин сувд” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байгаа бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авхад нь тус бүр 20.000.000 (хорин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тайлант хугацаанд давхардсан тоогоор 93 хүүхдийг хамруулан хүүхэд тус бүр дээр хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байгаа нь үр дүнгээ өгч байна.			
--	--	--	--	---	--	--	--

			сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт, 4.10. бага орлоготой, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг судлан сайжруулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.				
23.	27.	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх	Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг “Эрүүл мэндийн боловсролыг дэмжих ухуулга, нөлөөллийн арга хэмжээ, зан үйлийг өөрчлөх, мэдээлэл, сургалт сурталчилгааны төрөл, чанарыг сайжруулж, иргэдийн сонирхол төрүүлэхүйц шинэлэг, сонирхолтой хэлбэрээр хэрэгжүүлэх”, “Халдварт бус өвчлөл, өвчний эрт үеийн хяналт, тандалтыг сайжруулах, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх”, “Умайн хүзүүний хорт хавдрын цогц хяналтын зааврын танилцуулга”, “Хорт хавдрын өвчлөл, өвчний эрт үеийн хяналт, тандалтыг сайжруулах, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх” зэрэг сэдвийн хүрээнд дотоодын 2 сургалтад 36 мэргэжилтэн хамрагдсан. 2024 оны эхний 2			НХХ

			шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	сарын байдлаар бөөр шээсний замын эрт илрүүлэг шинжилгээнд 596 иргэн хамрагдаж, бөөрний нарийн мэргэжлийн эмчид 98 иргэн үзүүлсэнээс 26 иргэн өдрийн эмчилгээнд хамрагдсан.			
24.	28.	2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 46 дугаар тэмдэглэл 2022-09-22 Дугаар 2022_46	Х.5. Үүнтэй холбогдуулан уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж Улаанбаатар хот, дүүргийн удирдлага, хороодын Засаг дарга, хорооны хэсгийн ахлагч нараас тавьсан санал, хүсэлтийг судалж, шаардлагатай бол төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэн үр дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид тус тус даалгав.	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр нийслэл, дүүргийн удирдлага, хороодын Засаг дарга нар, хэсгийн ахлагч нартай хийсэн уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Баянзүрх дүүрэгт хамаарал бүхий 3 арга хэмжээний биелэлтийг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. Тус 3 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 55.3 хувьтай байна.			ТЗУХ
25.	29.	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	ХИҮ.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг,	2024 оны 03 дугаар сарын байдлаар Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газарт зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажил хийгдээгүй болно.			ТЗУХ

			нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;				
26.	30.	2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр 8 дугаар тэмдэглэл 2023-02-08 Дугаар 2023_8	IX.2. Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн батлагдсан төсвийн багцын дүнд хийсэн хөрөнгийн зохицуулалтыг Монгол Улсын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид зарцуулах зорилгоор санхүүжилтийн зохицуулалт хийх арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	2022 онд Баянзүрх дүүрэгт төсвийн хөрөнгө оруулалтаар 45 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн батлагдсан төсвийн багцын дүнд хийсэн хөрөнгийн зохицуулалтыг 2023 онд хийхээр Улсын төсөвт тусган ажилласан. 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 60 төсөл, арга хэмжээг 112 тэрбум 825 сая төгрөгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн.			ТГУХ
27.	31.	2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10	XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	МЭЭГ-ын даргын А/87 тоот тушаал, Нийслэлийн Засаг даргын А/399 тоот захирамж, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 03-ний өдрийн А/278 тоот захирамжийн хүрээнд Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд үхэр-18515, гахай-485 бүгд-19000 мал, амьтан хамруулах цахим системд төлөвлөгөө гаргаж, дүүргийн хэмжээнд зохион байгуулж, арга хэмжээний явцад Баяндэмбэрэл ХХК, Жижиг зээрд ХХК, МЭГ ХХК мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдийн эмч, ажилчдыг удирдлага, арга зүйгээр ханган ажилласан.			ХХҮХ
28.	32.	2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл	IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй	Нийслэлийн Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт газар өмчлөх, эзэмших , эрх олгох шийдвэр гаргаагүй болно. Мөн газар олголтой			ГЗБА

		2023-03-22 Дугаар 2023_13	байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав.	холбоотой мэдээлэл EGAZAR.GOV.MN цахим хаягт нээлтэй тавигдаж байна.			
29.	33.	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга)-д зааснаар Нийтийн мэдээлэл хариуцагч байгууллага нь Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор 98 мэдээллийг байнга ил тод байлгахгаар хуульчилсан. Монгол Улсын Засгийн газраас			ТЗУХ

			газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.	гаргадаг нээлттэй мэдээллийн хувийг харуулах шилэн индексийн үзүүлэлтээр Баянзүрх дүүрэг 100 хувьтай байна. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг Shilen.gov.mn веб сайт руу шууд холбогдох хэлбэрээр нэмж оруулж байна.			
30.	34.	2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25	XIII.5.2. 2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,	Дүүргийн хэмжээнд 101 төрийн албан хаагчийг 2023 оны 06 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан "Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх" богино хугацааны сургалтад хамруулж 101 албан хаагчид сертификат авсан.			ТЗУХ

31.	35.	2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2023-09-26 Дугаар 2023_39	XVIII.1.1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авахыг холбогдох Засгийн газрын гишүүд, барилга байгууламжийн захиалагч нарт даалгав: 1.2024 онд шилжэн хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг эрчимжүүлж, гэрээт ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг хянаж, үнийн өсөлтийг бодитойгоор тооцож, дүгнэхийг захиалагч нарт;	2024 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс Баянзүрх дүүрэгт 10 төсөл, арга хэмжээ эрх шилжин ирсэн. Үүнтэй холбоотойгоор 9 төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг боловсруулан дүүргийн худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн. Бусад төсөл арга хэмжээний ажлын даалгаврыг боловсруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.			ТГУХ
	36.		XVIII.1.2. Хуульд заасан хугацаанд хэрэгжээгүй, 2023 онд ажлын гүйцэтгэл дутуу барилга байгууламжийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэлийг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дүгнэж, зайлшгүй шаардлагатай бол гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг захиалагч нарт	2023 онд ажлын гүйцэтгэл дутуу болон зайлшгүй шаардлагатайгаар гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авсан төсөл, арга хэмжээ байхгүй болно.			
	37.		XVIII.1.10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	2025 оны төсвийн саналд тусгах төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, жагсаалтыг боловсруулан, холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган ажиллаж байна.			
32.	38.	2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр тэмдэглэл	2.93. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр нийслэл, дүүргийн удирдлага, хороодын Засаг дарга, хорооны хэсгийн	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр нийслэл, дүүргийн удирдлага, хороодын Засаг дарга нар, хэсгийн ахлагч нартай хийсэн уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэх			ТЗУХ

		2023-10-04 Дугаар 2023_40	ахлагч нартай, 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр нийслэлийн Баянзүрх дүүргийн иргэдтэй хийсэн уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт	арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Баянзүрх дүүрэгт хамаарал бүхий 3 арга хэмжээний биелэлтийг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. Тус 3 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 55.3 хувьтай байна.			
33.	39.	2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 41 дүгээр тэмдэглэл 2023-10-11 Дугаар 2023_41	XVII.1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Баянзүрх дүүргийн Засаг даргын 2024 оны “Сар шинийн баярыг угтсан их цэвэрлэгээ, орчны аюулгүй байдал хангах ажил зохион байгуулах тухай” А/68 дугаар захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хог хаягдал, цас мөс цэвэрлэх ажлыг зохион байгууллаа. Цэвэрлэгээний хүрээнд 2,389,415 м.кв зам талбайн мөс цас, хог хаягдал цэвэрлэж 1,423 тн хар цас тээвэрлэн ажилласан. 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 02 дугаар сарын 12-ны өдрүүдэд хог тээврийн 6 байгууллага айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын 9,401 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн.			ТНААХ
34.	40.	“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-04-17 Дугаар 2023_01	1.5. Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2008 оноос хойших шийдвэрийн талаарх мэдээллийг нэгтгэн хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	2008-2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хүртэлх Баянзүрх дүүргийн засаг даргын захирамжаар 69989 иргэн хуулийн этгээдэд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон байна. Мөн НГЗБА-нд дээрх мэдээллийг нэгтгэн хүргүүлсэн.			ГЗБА
	41.		1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож,	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга)-д зааснаар Нийтийн мэдээлэл хариуцагч байгууллага нь Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон			ТЗУХ

			тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	нийтийн хяналтыг бий болгох зорилгоор 98 мэдээллийг байнга ил тод байлгахаар хуульчилсан. Монгол Улсын Засгийн газраас гаргадаг нээлттэй мэдээллийн хувийг харуулах шилэн индексийн үзүүлэлтээр Баянзүрх дүүрэг 100 хувьтай байна.			
35.	42.	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай 2023-07-25 Дугаар 2023_03	2.. 2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 2.1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө, захирамж, удирдамж гарган хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах; 2.2. Нийт мал сүрэгт үзлэг ангилалтын ажлыг технологийн дагуу хийж, стандартын шаардлага хангахгүй үржлийн малын 10 хүртэлх, дундаас доош тарга хүчтэй, эр сувай малын 50 хүртэлх хувийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах; 2.3. Хээлтүүлэгчийн үзлэг ангилалт, заазлалтыг чанартай гүйцэтгүүлэх, дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн тавих, хээлтүүлгийн ажлыг технологийн хугацаанд хийж хэрэгжүүлэх; 2.4. Мал, эмнэлгийн үйлчилгээг шуурхай, чанартай зохион байгуулах, хот суурин газарт нэвтрэх мал, мах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгохдоо вакцинжуулалт, тарилга, туулгалтын хугацааг сайтар				ХХҮХ

			хянах, тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, зам дагуу байрлах орон нутгийн чанартай хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх; 2.5. Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах, говийн бүсийн болон хадлангийн нөөц багатай аймгуудад хадлан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь хийж гүйцэтгэх; 2.6. Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлэн байдал, зохион байгуулалтыг бүрэн хангуулах, цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах; 2.7. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж орлого бүрдүүлэлтийг ил тод болгох, орлогын эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрэмбэлэн зарцуулах, хяналт тавих; 2.8. Бэлчээрийн даац, багтаамжид тулгуурлан аймаг, сум дундын отрын бүс нутаг, улсын хилийн зурвас болон байгалийн тусгай хамгаалалттай газар нутагт отроор өвөлжүүлэх малчин өрх, мал сүргийн тоог харилцан тохиролцож гэрээ байгуулан ажиллах, бүс алгасаж				
--	--	--	---	--	--	--	--

			отор нүүдэл хийхгүй байхад анхаарах; 2.9. Отроор нүүдэллэж байгаа малчин өрхийг тухайн нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах; 2.10. Орон нутгийн тусгай хэрэгцээний газарт отор нүүдэл хийх журмыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж, мөрдөн ажиллах;				
--	--	--	--	--	--	--	--